



**МОНГОЛЫН
ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО**

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ
ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ
2023 – 2025 ОНЫ ТАЙЛАН**



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ 2023 – 2025 ОНЫ ТАЙЛАН

Монголын Хуульчдын холбооны 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн Зөвлөлийн ээлжит бус хурлаар Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны (цаашид Шалгалтын хороо гэнэ) гишүүдийг батламжилсан ба ийнхүү шинэ бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж эхэлсэн байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт “Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо нь Хуульчдын холбооны гишүүн, хуульч профессоруудын төлөөлөл оролцсон 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна” гэж заажээ.

1. Б.Амарбаясгалан – Шүүгчдийн төлөөлөл, хорооны дарга
2. Э.Золзаяа – Шүүгчдийн төлөөлөл, гишүүн
3. С.Энхбаяр – Шүүгчдийн төлөөлөл, гишүүн
4. Т.Мөнх-Эрдэнэ – Шүүгчдийн төлөөлөл, гишүүн
5. Д.Дамдинсүрэн – Прокурорын төлөөлөл, гишүүн
6. Б.Эрхэмбаяр – Прокурорын төлөөлөл, гишүүн
7. Т.Золбоо – Өмгөөлөгчдийн төлөөлөл, гишүүн
8. Д.Оросоо – Өмгөөлөгчдийн төлөөлөл, гишүүн
9. В.Оюумаа – Хуульч профессорын төлөөлөл, гишүүн
10. Б.Буянхишиг – Хуульч профессорын төлөөлөл, гишүүн
11. М.Мөнхбат – Хуульч профессорын төлөөлөл, гишүүн
12. Б.Баасандорж – Хуульч профессорын төлөөлөл, гишүүн

Хорооны мэргэжилтнээр 2023-2024 онд Г.Сарангэрэл, 2024-2026 онд Б.Бямба-Оюун нар ажиллажээ.



Шалгалтын хороо нь 2023 - 2025 онд 34 удаа цахим болон танхимаар хуралдаж Хуульчийн мэргэжлийн шалгалтын бүртгэл, хураамж, зохион байгуулалт, шалгалтын зохион байгуулалтын болон дүгнэх комисс байгуулах, өргөдөл, гомдолтой холбоотой нийт 70 гаруй асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байдаг.

ШАЛГАЛТЫН ТОВ, БҮРТГЭЛИЙН ТУХАЙД

Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Хуульчдын холбооны Зөвлөл нь Шалгалтын хорооноос ирүүлсэн хүсэлтийг үндэслэн тухайн жилд зохион байгуулах шалгалтын товыг тогтоодог.

шинээр боловсруулагдсан сорилго, гарын авлагын талаарх зэрэг шаардлагатай мэдээллийг өгдөг.

2023 оноос хэвлэлийн хуралд Холбооны тамгын газрын дарга, Шалгалтын хорооны төлөөлөл, мөн зохион

Он	Зөвлөлийн хурлын шийдвэр	Шалгалт явагдах өдөр
2023	Зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит бус хурлын 26 дугаар тогтоол	2023 онд 10 дугаар сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 27-ны өдрүүдийн хооронд
2024	Зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит бус хурлын 6 дугаар тогтоол	2024 онд 10 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 18-ны өдрүүдийн хооронд
2025	Зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит бус хурлын 11 дүгээр тогтоол	2025 онд 10 дугаар сарын 22-ны өдрөөс 10 дугаар сарын 24-ний өдрүүдийн хооронд

Үүнтэй холбогдуулан Шалгалтын хорооноос байгуулагдсан Шалгалтын зохион байгуулалтын комиссоос 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр, 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр, 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр тус онд явагдах шалгалтын тов, түүнтэй холбогдох бусад мэдээллийг олон нийтэд өгөх зорилгоор хэвлэлийн бага хурлыг зохион байгуулсан.

Тус хэвлэлийн хурлаар шалгалтын бүртгэл эхлэх, дуусах хугацаа, шалгалт явагдах өдөр, шалгалтын бүртгэлтэй холбоотой бусад болон Шалгалтын хорооноос явагдах сургалтын мэдээлэл, өмнөх жилийн бодлогын сургалтын үнэлгээний тайлан, мөн тухайн жилд

байгуулалтын комисст орж ажиллах шүүгч, прокурор, өмгөөлөгч, хууль профессорын төлөөлөл оролцдог болсон. Ийнхүү Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Хуульчийн шалгалтын товыг уг шалгалт эхлэхээс 75-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана”, 14.4 хэсэгт “Хуульчийн шалгалтад оролцогчийг бүртгэх ажиллагаа шалгалтын товыг зарласан өдрөөс эхэлж, шалгалт эхлэхээс 30 хоногийн өмнө дууссан байна” гэж заасны дагуу хуульчийн шалгалтын бүртгэлийн ажиллагааг эхлүүлдэг байна.



Хуульчийн мэргэжлийн шалгалтын бүртгэлийн хураамжийн хэмжээг нэмэгдүүлэх Шалгалтын хорооны санал, судалгааг хуульчдын холбооны Зөвлөлд 2 удаа хүргүүлснээс 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар 200.000 төгрөг, 2025 оны 06 дугаар сарын 26-ны хуралдаанаар 250.000 төгрөг болгож нэмэгдүүлсэн.

Шалгалтын зохион байгуулалтын хувьд дурдахад тус шалгалт нь төрийн албаны шалгалт болон бусад төрийн байгууллагын зүгээс зохион байгуулдаг аливаа шалгалттай адилтгах боломжгүй юм.

Жил бүрийн оролцогчдын тоог дунджаар 1.200 орчим гэж тооцож үзвэл төдий

хэмжээний эрх зүйчдийн цахим хэлбэрээр шалгалт өгөх танхим, компьютер, зохион байгуулалтын комисст ажиллах хүмүүсийг хууль тогтоомжид заасан төлөөллийн дагуу бэлтгэх, бүрдүүлэх үүргийг тухайн жилийн шалгалтын хороо хариуцаж ажилладаг.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу тус шалгалтыг зохион байгуулах нь төрийн байгууллагын аливаа дэмжлэггүй учир өнөөгийн бодит нөхцөлд видео тоглоомын газар зохион байгуулахаас өөр сонголтыг олгохгүй байх учир Монголын Хуульчдын холбооны зүгээс бие даасан зориулалтын шалгалтын танхим, төхөөрөмжийг бэлтгэж чаддаггүй билээ.

¹ 2023 оноос өмнө шалгалтын зардал нь бүртгүүлэгчдийн хураамжийн орлогоос илүү гарч хуульчдын холбооны төсөв буюу гишүүдийн татвараас төлөгдсөн, мөн инфляцийн үнийн өсөлт, ажиллах хүчний цалинг нэмэгдүүлэх зорилгоор хураамжийн хэмжээг 200.000 төгрөг болгож нэмэгдүүлсэн байдаг бол 2025 оны хэрэглээний үнийн индекс, бодит зардлын хэмжээг уялдуулах гэсэн 2 аргаар судалгаа хийж нийт гарах зардлын хэмжээг тогтоож нийт гарах зардалд хуваан тооцож, хураамжийн хэмжээг 250.000 төгрөг болгох нь зүйтэй гэх тооцоолол гаргасан байдаг

Гэвч бодит байдалд нийцүүлэн шалгалтад оролцогчдын саналын дагуу зохион байгуулалтыг жил бүр сайжруулан ажиллаж байна. Эрх зүйчдийн гаргасан шалгалтын үр нөлөөг дээшлүүлэхтэй холбоотой саналуудыг харгалзан үзэж хойшид улам чанаржуулахыг зорино.

Монголын Хуульчдын холбоо нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан журмын дагуу шалгалтын санхүүжилтийг бүрдүүлж ажилладаг бөгөөд шалгуулагч нь өөрийн шалгалттай холбоотой гарах зардлыг хариуцдаг. Шалгуулагч нь шалгалтад тэнцсэн эсэхээс үл хамааран эхний ээлжинд сорилгын шалгалт, улмаар бодлогын шалгалтад оролцдог бөгөөд үүнд түрээс, зохион байгуулалт, бичиг хэрэг зэрэг зардал тогтмол гардаг.

Тодруулбал, 2025 оны шалгалт дээр жишээлэн авч үзэхэд сорилгын шалгалтыг 6 байршилд цахим тоглоомын төвд 1 өдөр, бодлогын шалгалтыг 7 байршилд цахим тоглоомын төвд 2 өдөр зохион байгуулсан. Тоглоомын төв нь өглөө шалгуулагч ирэхэд бэлэн байх шаардлагатай учир бүтэн өдрөөр түрээсийн зардлыг авдаг бөгөөд байршлаас хамааран дунджаар 5.0 сая төгрөгийн зардал гардаг. Ингээд тооцож үзвэл 7 байршилд 2 өдөр нийтдээ 70.0 гаруй сая төгрөгийн түрээсийн зардлыг бодлогын шалгалтын хугацаанд, 6 байршилд 1 өдөр 30.0 гаруй сая төгрөг

нийтдээ 100.0 гаруй сая төгрөг зөвхөн түрээсийн зардалд зарцуулагдаж байна. Үүнээс гадна хуульчийн мэргэжлийн шалгалтыг зохион байгуулахад хөндлөнгийн хянагч, улсын бүртгэлийн ажилтан, Хуульчдын холбооны Тамгын газрын нийт ажилтан, нийтийн хэв журам сахиулах цагдаагийн албан хаагч, жолооч, зохион байгуулалтын комиссын гишүүд гээд нийт 90 гаруй хүн оролцдог бөгөөд тэд нарт ажлын 3 өдөр ажилласан цагийн хөлс, мөн дүгнэх комиссын гишүүд бодлогыг амралтын 2 өдөр дүгнэж ажилласан, гомдлыг дахин амралтын 1 өдөр хянан ажилласан цагийн хөлс, мөн сорилго, бодлого боловсруулах зохиогч нарт олгох урамшуулал, бодлогын сургалт явуулах багш нарын цагийн хөлс зэрэг нь шалгуулагчийн шалгалтын хураамжид багтдаг болно.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийг төгсөж, хоёроос доошгүй жил мэргэжлийн дадлага хийсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульчийн шалгалтад орох эрхтэй” гэж заасан байдаг.

Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох ажил, албан тушаалыг заасан.

Он	Бүртгэлийн хугацаа	Нийт бүртгүүлсэн	ЗБК эрх олгон	Татгалзсан	ШХ зөвшөөрсөн	Эрх олгосон нийт
2023	2023.07.27 – 2023.09.10	1.323	1.174	149	72	1.246
2024	2024.08.02 – 2024.09.15	1.211	1.065	146	78	1.143
2025	2025.08.08 – 2025.09.21	1.287	1.171	116	45	1.216



ШАЛГАЛТЫН ХОРООНООС БАЙГУУЛАХ КОМИССЫН ТУХАЙД

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 52 дугаар зүйлийн 52.3.1, Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын 3.1 дүгээр зүйлийн 2, 2.1 дэх хэсэгт зааснаар Шалгалтын хороо нь шалгалтын зорилго, төрөл, зохион байгуулах үйл ажиллагааг харгалзан дараах 2 комиссыг байгуулдаг.

Эдгээр комисс нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 62 дугаар зүйлд зааснаар нэг удаагийн байна. Үүнд:

- Шалгалтын зохион байгуулалтын комисс;
- Бодлогын шалгалтын даалгаврыг дүгнэх комисс.

2023 оноос эхлэн Шалгалтын хорооноос дээрх хоёр комиссыг байгуулахад аль болох шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны болон хуульч профессоорын төлөөллүүдийн тэгш оролцоог хангахад анхаарч ажилласан.

а.Шалгалтын зохион байгуулалтын комисс

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэг, Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Шалгалтын хороо нь шалгалт зохион байгуулах бүрд Хуульчийн мэргэжлийн шалгалтын зохион байгуулалтын комиссыг (цаашид Шалгалтын комисс гэнэ) байгуулдаг байна.

Энэхүү шалгалтын комисс нь тухайн жилийн хуульчийн шалгалтын зохион байгуулж явуулдаг. Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төрийн захиргааны төв байгууллага болон Хуульчдын холбооны энэ журмын 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хороодоос шалгалтын зохион байгуулалтын комисст ажиллах гишүүдийн нэрсийг авах, хэлэлцэж шийдвэрлэх ажлыг Шалгалтын хороо, Хуульчдын холбооны Тамгын газартай хамтран зохион байгуулна” гэж заасны дагуу Шалгалтын хороо, Холбооны Тамгын газартай хамтран Хууль зүй, дотоод хэргийн яам, Хуульчдын холбооны Шүүгчдийн хороо, Өмгөөлөгчдийн хороо, Прокурорын хороо, хууль зүйн их, дээд сургуулиудад Шалгалтын комисст ажиллах боломжтой, шаардлага хангасан хуульчийн нэр, холбогдох мэдээллийг ирүүлэх тухай албан бичиг хүргүүлдэг.

Хуульч профессорын төлөөлөлд ажиллах багш нарыг сонгохдоо Монгол Улсад идэвхтэй, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, багшлах боловсон хүчин сайтай сургуулиудыг (тухайлбал, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургууль, Шихихутуг их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Их Засаг их сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Сити их сургууль, Орхон их сургууль зэрэг) хамруулсан байгаа.

² 149 татгалзсанаас баримт бичгийн бүрдэл дутуу үндэслэлээр - 98, дадлагад тооцох хугацаа хүрээгүй /2 жилийн хугацаа хүрээгүй/ гэх үндэслэлээр - 32, мэргэжлийн дадлагад тооцох ажил эрхлээгүй - 19 бүртгүүлэгчид эрх олгоогүй

³ 146 татгалзлаас баримт бичгийн бүрдэл дутуу үндэслэлээр - 100, дадлагад тооцох хугацаа хүрээгүй /2 жилийн хугацаа хүрээгүй/ гэх үндэслэлээр - 32, мэргэжлийн дадлагад тооцох ажил эрхлээгүй - 14 бүртгүүлэгчид эрх олгоогүй

⁴ 116 татгалзлаас баримт бичгийн бүрдэл дутуу гэх үндэслэлээр - 70, дадлагат тооцох хугацаа хүрээгүй /2 жилийн хугацаа хүрээгүй/ гэх үндэслэлээр - 23, мэргэжлийн дадлагад тооцох ажил эрхлээгүй - 23 бүртгүүлэгчид эрх олгоогүй

2023 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2, шүүгдийн хорооноос 3, прокурорын хорооноос 3, өмгөөлөгчдийн хорооноос 3, хууль зүйн их, дээд 4 сургуулиудаас 14 багш, 2024 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2, шүүгдийн хорооноос 3, прокурорын хорооноос 3, өмгөөлөгчдийн хорооноос 4, хууль зүйн их, дээд 5 сургуулиудаас 13 багш, 2025 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 1, шүүгдийн хорооноос 3, прокурорын хорооноос 3, өмгөөлөгчдийн хорооноос 3, хууль зүйн их, дээд 6 сургуулиудаас 12 нэр дэвшигчийн мэдээллийг тус тус ирүүлсэн. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Шалгалтын комисст шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны болон хуульч профессоруудын төлөөлөл орно”, Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шалгалтын зохион байгуулалтын комисс нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5-д заасан төлөөллийг хангасан 13-15 гишүүний бүрэлдэхүүнтэй байна” гэж заасан байдаг.

Он	Шалгалтын зохион байгуулалтын комиссын бүрэлдэхүүн						
	ХЗДХЯ	Шүүгчдийн хороо	Прокурорын хороо	Өмгөөлөгчдийн хороо	Хуульч профессор	Шалгалтын хороо	Нийт
2023	2	2	2	2	4	3	15
2024	2	2	2	2	5	-	13
2025	1	2	2	2	5	-	12

“Хуульчийн мэргэжлийн шалгалтын журам”-ын 3.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Шалгалтын хорооны дарга нь шалгалтын зохион байгуулалтын комисс болон дүгнэх комиссыг тус тус даргална”, 4 дэх хэсэгт “Шалгалтын комиссын нарийн бичгийн дарга нь Хуульчдын холбооны Тамгын газрын шалгалт хариуцсан мэргэжилтэн байна” гэж тус тус заасны дагуу комиссын дарга, нарийн бичгийн дарга нарыг оролцуулан Шалгалтын хорооны 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар 17 гишүүн, 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар 15 гишүүн, 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар 14 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтын зохион байгуулалтын комиссыг тус тус баталсан байна.





Шалгалтын комиссын бүрэлдэхүүний хуульч профессорын төлөөлөлд 2023 – 2025 оны хооронд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургууль, Шихихутуг ИС, Отгонтэнгэр ИС, Их Засаг ИС, Орхон ИС, Сити ИС зэрэг сургуулийн багш нар оролцож ажилласан байна.

2024 онд шалгалтад бүртгүүлэгчдийн хүсэлтээр Хуульчдын холбооны Тамгын газар болон Шалгалтын комиссоос шалгалтад бүртгүүлэх гэж байгаа болон бүртгүүлсэн иргэдэд нэгдсэн мэдээлэл өгч, сонирхсон асуултад хариулах цахим уулзалтыг зохион байгуулсан болно.

б.Дүгнэх комисс

Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Дүгнэх комисс нь мэргэжлийн ёс зүйн алдаа зөрчилгүй, хууль зүйн магистр ба түүнээс дээш зэрэгтэй Хуульчдын холбооны шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хороо болон хуульч профессорын тэнцвэртэй тооны төлөөллийг хангасан 15-27 гишүүний бүрэлдэхүүнтэй байна”, 2 дахь хэсэгт “Шалгалтын комиссын дарга дүгнэх комиссыг энэ журмын 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан эрх зүйн салбар тус бүрээр 5-9 хүртэл гишүүнтэй 3 хэсэгт хуваан гишүүдийн нэрс, ажиллах хуваарийг батална” гэж тус тус заасныг үндэслэн Хуульчийн мэргэжлийн шалгалтын бодлогын даалгавар дүгнэх комиссыг байгуулахаар Шалгалтын хороо, Тамгын газартай хамтран Шүүгчдийн хороо, Прокурорын хороо, Өмгөөлөгчдийн хороо, хууль зүйн их, дээд сургуульд албан бичиг хүргүүлсэн байдаг.

Дээрх хороод болон хууль зүйн их, дээд сургуулиудаас ирүүлсэн нэрсийг Шалгалтын хорооноос хүн тус бүр дээр хэлэлцэн хорооны гишүүдийн дунд нууц санал хураалт явуулж, тухайн жилийн бодлого дүгнэх комиссыг салбар тус бүр дээр 9 гишүүн, нийт 27 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Тодруулбал, 2023 онд Шүүгчдийн хорооноос 12, Прокурорын хорооноос 4, Өмгөөлөгчдийн хорооноос 11, хууль зүйн их, дээд сургуулиудаас 14 нэрс ирүүлснийг Шалгалтын хорооны 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар,

2024 онд Шүүгчдийн хорооноос 13, Прокурорын хорооноос 4, Өмгөөлөгчдийн хорооноос 14, хууль зүйн их, дээд сургуулиудаас 26 нэрс ирүүлснийг Шалгалтын хорооны 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар,

2025 онд Шүүгчдийн хорооноос 11, Прокурорын хорооноос 3, Өмгөөлөгчдийн хорооноос 14, хууль зүйн их, дээд сургуулиудаас 25 нэрс ирүүлснийг Шалгалтын хорооны 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Хугацаа	Эрүүгийн эрх зүйн бодлого дүгнэх комисс	Иргэний эрх зүйн бодлого дүгнэх комисс	Захиргааны эрх зүйн бодлого дүгнэх комисс	Нийт
2023 он	9 ⁵ (2 шүүгч, 2 прокурор, 2 өмгөөлөгч, 3 хуульч профессор)	9 ⁶ (3 шүүгч, 3 өмгөөлөгч, 3 хуульч профессор)	9 ⁷ (2 шүүгч, 3 өмгөөлөгч, 4 хуульч профессор)	27
2024 он	9 ⁸ (2 шүүгч, 2 прокурор, 2 өмгөөлөгч, 3 хуульч профессор)	9 ⁹ (3 шүүгч, 3 өмгөөлөгч, 3 хуульч профессор)	9 ¹⁰ (3 шүүгч, 3 өмгөөлөгч, 3 хуульч профессор)	27
2025 он	9 ¹¹ (2 шүүгч, 2 прокурор, 2 өмгөөлөгч, 3 хуульч профессор)	9 ¹² (3 шүүгч, 3 өмгөөлөгч, 3 хуульч профессор)	9 ¹³ (3 шүүгч, 3 өмгөөлөгч, 3 хуульч профессор)	27

Шалгалтын зохион байгуулалтын комиссын бүрэлдэхүүний хуульч профессорын төлөөлөлд 2023 – 2025 оны хооронд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургууль, Шихихутуг ИС, Отгонтэнгэр ИС, Их Засаг ИС, Удирдлагын академи зэрэг сургуулийн багш нар оролцож ажилласан байна.



БОДЛОГО БОДОХ АРГАЧЛАЛЫН СУРГАЛТЫН ТУХАЙД

2023 оноос эхлэн бодлого бодох нэгдсэн аргачлалыг боловсруулж, түүн дээр суурилсан бодлого бодох аргачлалын сургалтыг зохион байгуулдаг болсон. Энэхүү ажлыг салбартаа мэргэшсэн мэргэшсэн шүүгч, прокурор, өмгөөлөгч, хууль зүйн их, дээд сургуулийн профессор, багш, судлаач нарыг оролцуулан бодлого бодох нэгдсэн нэг аргачлалаар нэг салбар эрх зүйгээр 2 өдрийн, нийт 6 өдрийн хугацаатай сургалт явуулахаар Шалгалтын хорооноос шийдвэрлэсэн юм.

Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцогчдод зориулсан бодлого бодох аргачлалын сургалтыг Эрүүгийн, Иргэний, Захиргааны эрх зүйн салбар эрх зүйн чиглэлээр 2023 онд 10 удаагийн давтамжтай, 60 хоногийн, 2024 онд 4 удаагийн 24 хоногийн сургалт, 2025 онд 5 удаагийн давтамжтай, 30 хоногийн сургалт тус тус зохион байгуулагджээ /1 удаагийн сургалт нь 6 өдөр үргэлжилнэ. Нэг салбар эрх зүйн сургалт 2 хоног, 3 салбар эрх зүй нийлээд 6 хоног/.

Сургалтаар тохиолдол бүрт хууль хэрэглэх чадварыг олгох, дүн шинжилгээ хийлгэх, нэгдсэн аргачлалаар бодох болсноороо шинэлэг жишиг болж тогтсон.

Хугацаа	Хамрагдсан хүний тоо (давхардсан тоогоор)	Багшлах бүрэлдэхүүн
2023.08.14 – 2023.10.14	405	Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн 20 шүүгч болон 4 прокурор, 2 өмгөөлөгч, хууль зүйн их дээд сургуулийн 8 профессор багш нар
2024.09.02 – 2024.09.28	540	Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн 17 шүүгч болон 2 прокурор, 2 өмгөөлөгч, хууль зүйн их дээд сургуулийн 7 профессор багш нар
2025.09.01 – 2025.10.04	750	Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн 12 шүүгч , 2 өмгөөлөгч, хууль зүйн их дээд сургуулийн 5 профессор багш, 2 судлаач нар

⁵Прокурор, хуульч профессорын квот дээр Шалгалтын хорооноос 2 гишүүн оролцсон

⁶Хуульч профессорын квот дээр Шалгалтын хорооны 2 гишүүн орсон

⁷Хуульч профессорын квот дээр Шалгалтын хорооны 1 гишүүн орсон

⁸Прокурор, хуульч профессорын квот дээр Шалгалтын хорооноос 2 гишүүн оролцсон

⁹Хуульч профессорын квот дээр Шалгалтын хорооны 2 гишүүн орсон


¹⁰Өмгөөлөл, хуульч профессорын төлөөллийн квот дээр Шалгалтын хорооноос 2 гишүүн оролцсон

¹¹Прокурорын төлөөллийн квот дээр Шалгалтын хорооны 1 гишүүн оролцсон

¹²Шүүгч, хуульч профессорын төлөөллийн квот дээр Шалгалтын хорооны 2 гишүүн орсон

¹³Хуульч профессорын квот дээр Шалгалтын хорооны 1 гишүүн оролцсон

2025 оны сургалтаас эхлэн өмнөх жил Хуульчийн мэргэжлийн шалгалт өгч нэгдүгээр байранд орсон эрх зүйчийн өөрийнх нь зөвшөөрлийг нь үндэслэн сургалт заах бүрэлдэхүүнд хамруулах болсон. Энэ нь тухайн шалгуулагч бодлого бодоход юунд анхаарах, хэрхэн бэлдэх талаар өөрийн туршлагыг бусадтай хуваалцаж байх нь бусад шалгалтад бэлдэж байгаа хүмүүст илүү ойртсон, ач холбогдолтой ажил болно гэж дүгнэж байна. Цаашид Шалгалтын хорооноос тухайн жилд нэгдүгээр байранд орсон эрх зүйчээр бодлого бодох сургалтаар хичээл заалгахыг хэвшил болгох нь зүйтэй.



Бодлогын сургалтад оролцогчдоос жил бүр сургалтын зохион байгуулалт, орчин нөхцөлийн талаар, бодлогын сургалтад ашигласан кейс, бодлого тохиолдлууд оновчтой, ойлгомжтой байсан эсэх, сургалтын үргэлжлэх хоног, хугацааны хувьд хэр үр дүнтэй байсан эсэх, сурагч багш нарын арга барил, сургалтын слайд оновчтой тодорхой байсан эсэх талаар сэтгэл ханамжийн судалгаа авахад дийлэнхи олонхи нь буюу 70-аас дээш хувь нь хангалттай сайн гэсэн үнэлгээ өгсөн байна. Ийнхүү сургалтын талаарх судалгааг нийт оролцогчдоос авч байгаа нь цаашид сургалтад анхаарах ямар асуудал байна, багш нарын заах арга барил, ойлгуулах чадвар зэрэгт анализ хийж, ирэх онд явагдах сургалтыг сайжруулахад чиглэж байгаа юм.

¹⁴Улсын дээд шүүхийн 9 шүүгч, давж заалдах шатны шүүхийн 6 шүүгч, анхан шатны шүүхийн 5 шүүгч

¹⁵Улсын дээд шүүхийн 9 шүүгч, давж заалдах шатны шүүхийн 4 шүүгч, анхан шатны шүүхийн 4 шүүгч

¹⁶Улсын дээд шүүхийн 4 шүүгч, давж заалдах шатны шүүхийн 3 шүүгч, анхан шатны шүүхийн 5 шүүгч



ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТ

Монголын Хуульчдын холбооноос жил бүр хуульч бүрийн зайлшгүй мэдвэл зохих эрх зүйн онол, суурь зарчим болон эзэмших ёстой хууль хэрэглээний чадварын түвшинг тогтоох хуульчийн мэргэжлийн шалгалтын улс орон даяар зохион байгуулсаар ирсэн.

Шалгалтын хороо нь олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, онолын болон практикийн туршлагатай, хариуцлагатай, мэргэшсэн, ёс зүйтэй шүүгч, прокурор, өмгөөлөгч, хууль зүйн их, дээд сургуулиудын профессор, хуульч нартай нууцын баталгаа авч, гэрээ байгуулан сорилго болон шалгалтын бодлогыг зохиолгодог болохыг дурдах нь зүйтэй.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт: *“Хуульчийн шалгалт нь эрх зүйн ерөнхий мэдлэгийг сорьсон сорилгын болон эрх зүйн салбарын хүрээнд тодорхой тохиодлыг хууль хэрэглэж шийдвэрлэх бодлогын шалгалтын хэлбэрээр явагдана”* гэж заасны дагуу шалгалт нь сорилго, бодлого гэсэн дарааллаар явагддаг.

а.Сорилго

Монголын Хуульчдын холбооны хуульчийн мэргэжлийн шалгалт хариуцсан хорооны зүгээс шалгалтын агуулга, сорилго боловсруулах, бодлого дүгнэх аргачлалд зохих шинэчлэлтийг хийн үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үүний нэг илрэл нь 2024 онд сорилгыг шалгалтыг орчин үеийн түвшинд хүргэх зорилгоор Монголын Хуульчдын холбоо АНУ-ын Засгийн газрын санхүүжилттэй Фулбрайтын хөтөлбөрт хамрагдсан билээ.

Ингэхдээ хөгжингүй орнуудад түгээмэл хэрэглэж буй арга зүйг баримтлан шалгуулагчийн онолын болон ур чадварыг бодит кейс дээр шалгахыг урьтал болгосон юм.

Эдгээр тестийн зөв хариулт өгөгдөөгүй тул шалгалтад оролцох эрх зүйчид тестийн хариуг автоматаар цээжлүүлэх бус, харин өөрсдөө тухайн тохиолдол дээр “урьдчилан” ажиллах замаар салбар эрх зүйн хууль хэрэглээний мэдлэгээ сайжруулах, эргэцүүлэн бодох, оюун дүгнэлт хийх замаар зөв хариуг олохоор хийгдсэн. Энэ нь шалгалтад оролцох эрх зүйчдийн бүтээлч ажиллагааг нэмэгдүүлэх зорилготой юм.

Ийнхүү шалгуулагч нь зөв хариулт өгөгдөөгүй тесттэй ажиллахдаа холбогдох хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, зөвлөмж, тайлбаруудыг зайлшгүй уншиж судлах хэрэгтэй.

Сорилгын шалгалтыг 2 ээлжээр нийт 5-6 салбар, бодлогын шалгалтыг 7-8 салбар болгон цахим тоглоомын төвд зохион байгуулдаг.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дах хэсэгт *“Хуульчийн шалгалтад оролцогч сорилгын шалгалтын нийт онооны 60 ба түүнээс дээш хувийг авсан бол бодлогын шалгалтад орох эрхтэй болно”*, Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын 9.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт *“... сорилгын*

шалгалтын даалгаврын гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой гомдлыг шалгалт өгсөн өдрийн 20 цаг хүртэл ... Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороонд ... бичгээр ирүүлнэ” гэж тус тус заасны дагуу 2023 онд нийт 27 , 2024 онд 92, 2025 онд 55 гомдол ирүүлснийг Шалгалтын хороо хянаад үзээд гомдлыг үндэслэлгүй гэж үзсэн болно.

б.Бодлого

Бодлогын тухайд Шалгалтын хорооны 2024 оны 08 дугаар сарын 30-ний өдрийн хурлаар “Хуульчийн мэргэжлийн шалгалтын эрх зүйн тохиолдлод боловсруулахад тавигдах шаардлага”-ыг баталсан. Энэхүү шаардлагын дагуу хуульчийн шалгалтанд өгөх бодлогыг зохиогч нар боловсруулдаг. Тодруулбал, агуулга нь материаллаг болон процессын хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх арга зүйд тохирсон хууль зүйн урьдчилсан нөхцөл байдлаар өгөгдсөн байх, тохиолдолд зүйлчлэл хийн хууль зүйн дүгнэлт өгөх нөхцөл дөрөв хүртэл байх бөгөөд 150 минут буюу 2 цаг 30 минутад шалгуулагч энгийн хүний дундаж хурдаар бичиж дуусахуйц байна, тохиолдлын нөхцөл нь агуулгын туйлын тодорхой ойлгомжтой байх бөгөөд хоёрдмол утга агуулаагүй байна, тохиолдол нь хууль зүйн дүгнэлт бичихуйц байх бөгөөд нотлох баримт, процессын бие даасан үйл ажиллагаа явуулахыг шаардаагүй байна, бодлогын нөхцөл нь хуульч, судлаачдын дунд нэг мөр шийдэгдээгүй онолын маргаантай асуудлыг агуулаагүй байна зэрэг шаардлагуудыг тавьдаг.

Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын 7.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан оролцогч бодлогын шалгалтад орох эрхтэй байна” гэж, 4 дэх хэсэгт “Дүгнэх комиссын гишүүд бодлогын агуулга, даалгаврын асуултыг харгалзан нэг зарчим, аргачлалаар дүгнэж, нэгдсэн дүнг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасан журмын дагуу гаргана” гэж тус тус заасны бодлогын шалгалтыг зохион байгуулсан.

Бодлогын үнэлгээ нь Хуульчийн мэргэжлийн шалгалтын журамд заасны дагуу мэргэжлийн ёс зүйн алдаа зөрчилгүй, хууль зүйн магистр ба түүнээс дээш зэрэгтэй Хуульчдын холбооны шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хороо болон хуульч профессорын тэнцвэртэй тооны төлөөллийг хангасан 15-27 хүртэл гишүүний бүрэлдэхүүн дүгнэх комиссын өгсөн үнэлгээгээр гардаг.

Ингэхдээ салбар бүр дээр 3 гишүүний үнэлгээний арифметик дунджаар шалгуулагчийн эцсийн үнэлгээ гарсан болно.

Хуульчийн мэргэжлийн шалгалтын журмын 9.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... бодлогын шалгалтын даалгаврын гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой гомдлыг дүн гарсан өдрөөс хойш ажлын нэг өдрийн дотор ... Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороонд ... бичгээр ирүүлнэ”, 9.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 9.3-т “Гомдолд дурдсан шаардлага үндэслэлтэй байна гэж бүрэлдэхүүн үзвэл гомдол гаргагчийн маргаж буй даалгаврын гүйцэтгэлийг дахин нягталж дүгнэх”, 9.4-т “Гомдол гаргагчийн бодлогын шалгалтын даалгаврын гүйцэтгэлийн анхны үнэлгээ болон энэ журмын 9.1 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу дахин нягталж үзсэн бодлогын шалгалтын үнэлгээний аль өндөр авсан үнэлгээгээр эцсийн үнэлгээг тооцно” гэж тус тус заасны дагуу дахин хянаж үзсэн болно. Тодруулбал,



- 2023 онд Эрүүгийн бодлого - 384, Иргэний бодлого - 383, Захиргааны бодлого - 375 гомдол,
- 2024 онд Эрүүгийн бодлого - 351, Иргэний бодлого - 352, Захиргааны бодлого - 340 гомдол,
- 2025 онд Эрүүгийн бодлого - 384, Иргэний бодлого - 383, Захиргааны бодлого - 375 гомдлыг тус тус гаргасан байна.

Шалгуулагч анхны үнэлгээнд гомдол гаргасан нөхцөлд мөн журамд заасны дагуу бодлогын шалгалтын даалгаврыг дахин хянаж үнэлсэн комиссын гишүүний үнэлгээ бодлогын даалгаврын анхны үнэлгээнээс 3 ба түүнээс дээш онооны зөрүүтэй дүгнэсэн байх тохиолдолд гишүүн өөрийн үнэлгээний үндэслэлийн талаарх тайлбарыг бичгээр гаргаж, тухайн өдөрт багтаан шалгалтын комиссын даргад өгч хяналтыг хэрэгжүүлэн ажилладаг.

Хэдийгээр аргачлалын дагуу эрх зүйн дүгнэлтийг хийж байгаа боловч учир шалтгааныг хууль хэрэглээний хувьд дэлгэрэнгүй тайлбарлаж чадаагүй байх, зүйлчлэл зөв байх ч эрх зүйн дүгнэлтийг тодорхой үндэслэл бүхий гаргаагүй ерөнхий хариулт өгөх нь ижил зүйлчлэл, аргачлал ашиглаж буй боловч ялгаатай үнэлгээ авах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой бөгөөд дүгнэх комиссын гишүүний үнэлж буй үнэлгээ болно.

Ийнхүү Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт “Сорилгын болон бодлогын шалгалтад авсан нийлбэр дүн нь хуульчийн шалгалтын нийт онооны 70 ба түүнээс дээш хувьд хүрсэн бол хуульчийн шалгалтад тэнцсэнд тооцно” гэж заасны дагуу 2023 онд 203, 2024 онд 205, 2025 онд 100 оролцогч нар Хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн байна.

Он	Сорилго явагдсан огноо	Шалгалтад орсон хүний тоо	Сорилгод тэнцсэн хүний тоо	Бодлогын шалгалт явагдсан огноо	Шалгалтад орсон хүний тоо	Бодлогод тэнцсэн хүний тоо	Нийт тэнцсэн хүний тоо
2023	2023.10.25	1.200	776	2023.10.26-27	753	203	203
2024	2024.10.16	1.029	714	2024.10.17-18	705	205	205
2025	2025.10.22	1.126	695	2025.10.23-24	682	100	100





ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТ - 2023

2023 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтад нийт 1323 оролцогч бүртгүүлснээс 1200 оролцогч шалгалтад оролцох эрхтэй болсон. Шалгалт нь эрх зүйн ерөнхий мэдлэг сорьсон сорилго ба эрх зүйн тохиолдол шийдвэрлэх бодлого гэсэн 2 үе шаттай явагдсан бөгөөд сорилгын шалгалтад 776 оролцогч тэнцэж, бодлогын шалгалт өгсөн. Үүнээс сорилгын болон бодлогын шалгалтын нийт дүнгээр 70 ба түүнээс дээш оноо авч 203 оролцогч тэнцсэн.



Шалгалтад
бүртгүүлэгчдийн тоо
1323



Шалгалтад орох
эрх олгосон
1200



Сорилгын шалгалтад тэнцсэн
буюу бодлогын шалгалт өгсөн
776



76

203
ТЭНЦСЭН



127

22 – 26 нас

114

27 – 31 нас

52

32 – 36 нас

25

37 – 41 нас

8

42 – 56 нас

4

ТӨГССӨН СУРГУУЛИЙН МЭДЭЭЛЭЛ:
Монгол Улсын Их Сургууль – 102
Их Засаг Олон улсын их сургууль – 28
Шихихутуг их сургууль – 24
Отгонтэнгэр их сургууль – 17
Дотоод хэргийн их сургууль – 11
Бусад - 21

Шалгалтын хамгийн
өндөр оноо



Нийслэл хотоос

176

Орон нутгаас

27




МОНГОЛЫН
ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО

2024 ОНЫ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТ

2024 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтад 1211 эрх зүйч бүртгүүлж, 1146 эрх зүйчид шалгалтад оролцох эрх олгосон. Сорилгын шалгалтад 24 ба түүнээс дээш оноо авсан 714 оролцогч тэнцэж бодлогын шалгалтад оролцох эрхтэй болсон. Нийт 205 оролцогч бодлого болон сорилгын шалгалтын нийлбэр дүнгээр 70 ба түүнээс дээш оноо авч 2024 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн "БАТЛАМЖ" гардууллаа.




ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН 205 ХУУЛЬЧИЙН СТАТИСТИК ДҮН МЭДЭЭЛЭЛ



АЖИЛ МЭРГЭЖИЛ

ШҮҮГЧИЙН ТУСЛАХ БОЛОН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	28
ПРОКУРОРЫН ТУСЛАХ	25
БЕЛГЭЭЛЭХЧИЙН ТУСЛАХ	27
БУСАД	115




ОРОН НУТАГ - ХАРЬААЛАЛ



НАСНЫ АНГИЛАЛ



ШАЛГАЛТАД ОРСОН ЖИЛ



СУРГУУЛЬ


МУИС	106
Шоожеутуг	15
Их засаг	46
Дотоод хэргийн их сургууль	8
Орон их сургууль	3
Отгонтэнгэр их сургууль	4
Батлан Хамгаалхын Их сургууль	1
Зохимж дээд сургууль	1
Олон улсын Улаанбаатарын их сургууль	1

Олон Улсын эдийн засаг бизнесийн их сургууль	1
Санхүү Эдийн засгийн их сургууль	5
Сутай дээд сургууль	2
Улаанбаатар-Эрдэм судлал дээд сургууль	2
Хөлийн цэргийн дээд сургууль	1
Хөөд их сургууль	1
Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль	1
Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургууль	2
Гадаадын Их дээд сургууль	5




МОНГОЛЫН
ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО

2025 ОНЫ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН ТООН МЭДЭЭ




ХҮЙС:



АЖИЛ МЭРГЭЖИЛ

Өмгөөлөгчийн туслах
Төрийн байгууллагын хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хуулийн зөвлөх, хуулийн асуудал хариуцсан ажилтан
Прокурорын туслах
Шүүгчийн туслах болон нарийн бичгийн дарга
Нотариатын туслах
Хууль зүйн сургуулийн багш, туслах багш, төрийн болон төрийн бус байгууллагын эрх зүйн судалгааны ажилтан



ХАРЪЯАЛАЛ



НАСНЫ АНГИЛАЛ



ШАЛГАЛТАД ОРСОН ЖИЛ



СУРГУУЛЬ

МУИС	50	Олон улсын Улаанбаатарын их сургууль	1
Их засаг	16	Отгонтэнгэр их сургууль	1
Дотоод хэргийн их сургууль	11	Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургууль	1
Шихихутуг	9	Халх шурам	1
Гадаадын их сургууль	3	Улаанбаатар Эрдэм судлал	1
Санхүү Эдийн засгийн их сургууль	2		
Ховд их сургууль	2		



“ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН СОРИЛГО” ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙД

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд зааснаар Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах чиг үүрэг 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс Монголын Хуульчдын холбоонд шилжиж ирсэн.

Энэ чиг үүргийн дагуу Хуульчийн мэргэжлийн шалгалтыг 2016-2025 онд нийт 10 удаа зохион байгуулж, 2248 хүн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна.

Шалгалтын хорооноос жил бүр “Хуульчийн мэргэжлийн шалгалтын жишиг сорилгын хураамж” нэртэйгээр зөв хариулт өгөгдсөн сорилгыг багтаасан гарын авлагыг шалгуулагчдад зориулан гаргадаг байсныг 2024 оноос эхлэн “Хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилго” нэртэй болгон өмнөх жилүүдээс өөр бүтэцтэй, онцлог бүхий болгосон.

2024 онд хэвлэгдсэн гарын авлага нь 3 хэсгээс бүрдэх болж, нэгдүгээр хэсэгт Монголын Хуульчдын холбооны шалгалтын сорилгын санд байсан зөв хариулт өгөгдсөн 3.459 тестүүдийг шинэчилсэн байгаа.

Хоёрдугаар хэсэгт шалгуулагчийн онолын мэдлэг болон ур чадварыг бодит кейс дээр шалгахыг урьтал болгож, зөв хариулт өгөөгүй 1.204 сорилго оруулсан. Энэ нь шалгуулагчийг сорилгод багтсан тохиолдлыг шинжлэн судлахдаа олон улсын туршлагыг харгалзан тестүүдийн асуулт, хариултыг автоматаар цээжлүүлэх, хууль хэрэглээний хувьд хэвшмэл байдлаас зайлсхийх зорилгоор тус өөрчлөлтийг оруулсан бөгөөд шалгуулагч өөрөө бие даан зөв хариултыг олох, тесттэй ажиллахдаа холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, зөвлөмж, тайлбаруудыг уншиж судлуулах байдлаар зохиогдсон болно.

Гуравдугаар хэсэгт хуульчийн мэргэжлийн шалгалтын агуулга, сорилго боловсруулах аргачлалд зохих шинэчлэлтийг хийх, сайжруулах зорилгоор АНУ-ын Засгийн газрын санхүүжилттэй “Фулбрайтын мэргэжилтний хөтөлбөр” төслийн хүрээнд Калифорнийн их сургуулийн профессор Мэй Лин Спенсерийн заасан аргачлалын дагуу эрүү, иргэн, захиргааны эрх зүйн чиглэлийн 10 ширхэг бодомжит (жишиг) сорилгыг оруулсан болно. Энэхүү тестийн шинэчлэл нь хуульчдын заавал мэдэх ёстой хуулийн нэр томъёо, ойлголт, суурь зарчмууд болон тэдгээрийг хууль харахгүйгээр хэрэглэх чадварыг шалгах зорилготой ба тестийг зохиоход аль болох хуулийн үг, зүйл заалт хэрэглэхгүйгээр амьдралд ойр энгийн ойлгомжтой байдлаар асуудлыг илэрхийлэхийг зорьсон. Иймд шинэчилсэн тест нь шалгуулагчийн хувьд илүү ойлгомжтой, хялбар энгийн байдлаар зохиогдсон.

2025 онд хэвлэгдсэн “Хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилго” нь бүтцийн хувьд өмнөх жилийн гарын авлагатай адил бүтэцтэй болсон. Нэгдүгээр хэсэгт Хуульчдын холбооны хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилгын санд байдаг тестүүдээс эрх зүйн ач холбогдол багатай, хууль тогтоомжоор өөрчлөгдөж, хүчингүй болсон тестүүдийг хасаж, дахин хянаж боловсруулан зөв хариулт өгөгдсөн 2.937 сорилгууд орсон бол хоёрдугаар хэсэгт аливаа нэг тохиолдолд дүн шинжилгээ хийж, зөв хариултыг эргэцүүлэн бодох, хууль, эрх зүйн мэдлэг дээрээ тулгуурлан хариулах

замаар ажиллах сорилгыг салбар эрх зүй тус бүрээр ангилан шинээр боловсруулсан. Зөв хариулт өгөгдөөгүй 1.786 сорилгууд байна. Гуравдугаар хэсэгт шалгуулагчийн салбар эрх зүй тус бүрийн ерөнхий ойлголт, суурь зарчим, эрхийн асуудлыг шалгах, аливаа тохиолдлын гарц гаралгааг ерөнхий мэдлэгийн хүрээнд мэдэж, таньж байгаа эсэхийг шалгах зорилго бүхий 18 жишиг сорилгыг оруулсан болно.

Шалгалтын зохион байгуулалтын комиссоос жил бүр шалгуулагч нараас авах сорилго санд орох тестийн тоо, нэг хүнд очих зөв хариулт өгөгдсөн, өгөгдөөгүй тестийн тооны харьцааг (2024 онд 80х20, 2025 онд 70х30 хувь) тогтоодог.

Тодруулбал, 2024 онд шалгуулагч бүрт өгөгдөх 200 асуултын 160 нь зөв хариулт өгөгдсөн сорилгоос 40 нь зөв хариулт өгөгдөөгүй сорилго байсан бол 2025 онд 200 асуултаас 140 нь зөв хариулт өгөгдсөн сорилгоос, 60 нь зөв хариулт өгөгдөөгүй сорилго байв. Тодруулбал,

Он	Зөв хариулт өгөгдсөн тестийн тоо (хувь)	Зөв хариулт өгөгдөөгүй тестийн тоо (хувь)
2024	80 %	20 %
2025	70 %	30 %

Хуульчийн мэргэжлийн шалгалтыг цаашид олон улсын чиг хандлагад нийцүүлэхээр зөв хариулт өгөгдсөн сорилгын тоог багасаж, харин зөв хариулт өгөгдөөгүй сорилгын тоог нэмэх байдлаар явуулж зөв хариулт өгөгдсөн сорилгыг халах байдлаар шалгуулагчийн мэдлэгийг сорих зорилт тавин ажиллаж байгаа болно.

“ЭРХ ЗҮЙН ТОХИОЛДОЛ ШИЙДВЭРЛЭХ АРГАЧЛАЛ” ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙД

Монголын Хуульчдын холбооноос жил бүр хуульчийн шалгалтын агуулга болон хэлбэрийг олон улсын түвшинд хүргэх зорилгоор өндөр хөгжилтэй улс орнуудын туршлагыг судалж, нэвтрүүлэн ажиллаж байна. Үүний нэг илрэл нь 2023 онд Шалгалтын хорооноос Баруун Европын орнуудад суралцаж төгссөн хуульчдаас баг бүрдүүлж “Эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргачлал” гарын авлага боловсруулан гаргасан байна. Тус гарын авлагад салбар эрх зүй бүрээр эрх зүйн тохиолдлыг шийдвэрлэх аргачлал, үүнийг жишээ бодлогууд дээр тайлбарласан байгаа.

Ингэснээр эрх зүйн тохиолдол бүрийг нэгдсэн аргачлалаар дүгнэх боломжтой болсон бөгөөд үүнийг хууль зүйн их, дээд сургуулиуд нэвтрүүлж эхэлж байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

2025 онд “Эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргачлал 2023” номыг 2 дахь удаагаа хэвлүүлсэн болно.



¹⁷Т.Золбоо, Б.Буянхишиг, Т.Мөнх-Эрдэнэ нар тус бүр 2 бодлогыг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргачлалын хамт боловсруулж, Улсын дээд шүүхийн шүүгч Г.Банзрагч, Б.Батцэрэн, Н.Баярмаа нар хянан тохиолдуулсан байна

ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН АРГА ЗҮЙГ ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Монголын Хуульчдын холбооноос хуульчийн мэргэжлийн шалгалтын агуулга, арга, хэлбэр, сорилго боловсруулах, бодлого дүгнэх аргачлалд зохих шинэчлэлтийг хийх, сайжруулах зорилгоор 2023 оны 6 дугаар сард АНУ-ын Засгийн газрын санхүүжилттэй “Фулбрайтын мэргэжилтний хөтөлбөр”-т хамрагдах төсөл бичиж илгээсэн ба Хуульчдын холбооны төсөл шалгарч тус хөтөлбөрийн мэргэжилтэн Калифорнийн их сургуулийн профессор Мэй Лин Спенсер 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 06 дугаар сарын 27-ны өдрийн хооронд нэг сарын хугацаатай Монгол Улсад ирж Хуульчдын холбоотой хамтран ажилласан.

Фулбрайт хөтөлбөрийн тухай

АНУ-ын Засгийн газрын санхүүжилттэй олон улсын боловсролын хөтөлбөр болох “Фулбрайтын мэргэжилтний хөтөлбөр” нь дэлхий даяар мэргэжлийн болон академик салбарын шилдэг мэргэжилтнүүд хүлээн авч буй орнуудын хэрэгцээнд нийцсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт, судалгаа хийх боломжийг бүрдүүлж, олон улсын харилцааг хөгжүүлэх, мэдлэг солилцох, хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр мэргэжилтэн, зөвлөхүүдийн солилцоог дэмжих замаар төсөл, хөтөлбөрүүдээ хэрэгжүүлдэг тул олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, цаашдын чиг хандлагыг тодорхойлоход түлхэц болох мэдлэг, ур чадварыг олгож чаддагаараа олон улсад үнэлэгддэг.

Монголын Хуульчдын холбооны хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилын шалгалтын агуулга, бүтэц, арга зүйг шинэчлэх ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн Калифорнийн Их Сургуулийн профессор Май Лин Спенсер нь Америкийн Нэгдсэн Улсын Калифорни мужийн хуульчийн мэргэжлийн шалгалтын тест боловсруулах чиглэлээр мэргэшсэн, клиник сургалтын чадварлаг багш, судлаач, мэргэжилтэн юм. Тэрээр Монгол Улсад нэг сарын хугацаанд ажиллахдаа 2 улсын хуульчийн шалгалтын тогтолцоо, тестийн болон бодлогын шалгалтын хэлбэр, агуулгад харьцуулалт хийх, шинэчлэл хийхэд анхаарах зүйлсийг тодорхойлох, зөвлөмж, зөвлөгөө өгөх, загвар тест боловсруулах зэргээр дэмжлэг үзүүлж ажилласан.

“Хуульчийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор хуульчийн мэргэжлийн шалгалтыг шинэчлэх нь” төслийн үр дүн

Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд одоогийн сорилын шалгалтад ашиглаж буй 250 тестийн агуулга, үр дүнг үнэлэхээс гадна манай улсын төрийн болон хууль, шүүхийн байгууллагуудад ажиллаж буй хуульчид болон ажил олгогчид хуульчийн мэдлэг, ур чадвартай холбоотой тулгамдаж буй бэрхшээлүүдийг судлах, ажил олгогчийн зүгээс хуульчийн ямар ур чадварыг илүү үнэлэх хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлох ажлуудыг хийлээ. Энэ





хүрээнд Монголын Хуульчдын холбооны удирдлага, хороодын тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүдээс гадна Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газрын төлөөлөлтэй уулзалт хийв. Тодруулбал,

АНУ-ын Засгийн газрын санхүүжилттэй олон улсын боловсролын хөтөлбөр болох “Фулбрайтын мэргэжилтний хөтөлбөр”-ийн зөвлөх Калифорнийн Их Сургуулийн профессор Мэй Лин Спенсер Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Хуульчийн мэргэжлийн шалгалтын хорооны дарга Б.Амарбаясгалан болон Удирдах зөвлөлийн гишүүдтэй 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр өргөтгөсөн уулзалт хийж төслийн танилцуулга болон төслийн үйл ажиллагааны нарийвчилсан хуваарь гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон.

2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Улсын ерөнхий прокурорын газрын Сургалт судалгааны хүрээлэнгийн захирал С.Бат-Орших, Сургалтын албаны дарга О.Алтангэрэл, Судалгааны албаны дарга Б.Мөнхдорж, Бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах прокурор Б.Эрхэмбаяр, хяналтын прокурор Б.Өнөрмаа болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт хийв.



Мөн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр профессор Мэй Лин Спенсер Улсын дээд шүүхийн төлөөл болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн төлөөлөлтэй уулзалт хийж хуульч сонгон шалгаруулах ажиллагаа, хуульчид байх ёстой ур чадвар, дутагдалтай тал зэрэг хуульчийн ур чадварыг үнэлэх асуудалд шинэчлэх шаардлагатай асуудлаар санал солилцсон.



“Хуульчийн мэргэжлийн шалгалтын агуулга, тогтолцоог шинэчлэх нь” төслийн хүрээнд 30 хуульч сургалтад хамрагдаж, хуульчийн шалгалтын тест зохиох 9 мэргэшсэн хуульч, сургагч багш бэлтгэв

Монголын Хуульчдын холбооны Зөвлөл, Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо, Сургалтын хорооны гишүүд болон сургагч багш нарт 2024 оноос эхлэн хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилын шалгалтын хэсэгт нэвтрүүлэх шинэчлэл, түүний зорилго, үр дүн, шинэ тест зохиох арга зүй, хуульчийн шалгалт зохион байгуулж буй олон улсын туршлага гэсэн агуулгын хүрээнд “Тестийн асуулт боловсруулах сургалт”, “Бодлогын шалгалтын асуулт боловсруулах сургалт”, “Эссэ бичихэд зориулсан рубрик бий болгох сургалт”, “MCQs, эссэ баталгаажуулах сургалт”-уудыг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 11-ний өдрийн хооронд зохион байгуулж 30 гаруй хуульч сургалтад хамрагдсан.



Хуульчдын холбооны Олон улсын эрх зүйн хороотой хамтран 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр “АНУ-ын хуульчийн мэргэжлийн шалгалтын тогтолцоо болон монголын хуульчийн мэргэжлийн шалгалтын шинэчлэл” сэдвээр “Фулбрайтын мэргэжилтний хөтөлбөр”-ийн зөвлөх Калифорнийн Их Сургуулийн профессор Мэй Лин Спенсер илтгэл хэлэлцүүлж, хуульч, эрх зүйчидтэй чөлөөт ярилцлага хийлээ.

Хуульчийн мэргэжлийн шалгалтын тест шинэчлэн боловсруулах

Профессор Мэй Лин Спенсер нь хуульчийн шалгалтын сорилгыг боловсронгуй болгох тал дээр түлхүү ажилласан бөгөөд хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилго боловсруулах онол, арга зүйн хичээл орж, сургагч багш нараар тест зохиолгон дадлагажуулах, зөвлөх зэргээр онол, практик хосолсон хэлбэрээр сургалт явуулж, сургалтын явцад зохиосон эрүү, иргэн, захиргааны эрх зүйн чиглэлийн 10 ширхэг сорилгыг 2024 оны “Хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилго” гарын авлагын гуравдугаар хэсэгт оруулсан.

Эцэст нь төслийн үр дүнг нэгтгэн дүгнэвэл олон улсын жишигт нийцсэн хуульчийн мэргэжлийн шалгалтын тест боловсруулах 9 мэргэшсэн хуульч, сургагч багш бэлтгэсэн, хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцох эрх зүйчдэд зориулсан шалгалтын агуулга, хэлбэрт орох өөрчлөлтийг агуулсан гарын авлага боловсруулсан, мөн 2024 оны хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилгын шалгалтын тестийн 10 хувийг шинэ арга зүйгээр боловсруулсан тест эзлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Монголын Хуульчдын холбоо хуульчийн мэргэжлийн шалгалтын агуулга, арга зүйг бүхэлд нь шинэчлэх ажлын эхний үе шат амжилттай хэрэгжиж дууссан бөгөөд цаашид дахин шинэ төсөл боловсруулж олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.

ШАЛГАЛТЫН ХОРООНЫ ГИШҮҮД ГЕРМАНЫ ХУУЛЬЧИЙН ХОЁРДУГААР УЛСЫН ШАЛГАЛТЫН ТАЛААР ТҮРШЛАГА СУДЛАВ

Хуульчийн шалгалт зохион байгуулалт, шалгалт авч буй хэлбэрийг өөрчлөх зорилгоор бусад улсын туршлага судлах ажлын хүрээнд Ханнс-Зайдел сангийн дэмжлэгтэйгээр ХБНГУ-ын Хуульчийн мэргэжлийн шалгалтын туршлагыг судлах айлчлалыг 2024 оны 06 дугаар сард хийсэн. Тус айлчлалын хүрээнд хуульчийн шалгалтын агуулга, хэлбэр, дүгнэх үнэлгээ, онооны зарчим, хараат бус шалгах комиссыг томилох явц зэрэг мэдээлэлтэй танилаж, туршлага



Айлчлалын бүрэлдэхүүнд Монголын Хуульчдын холбооны Шалгалтын хорооны дарга, Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын шүүгч Б.Амарбаясгалан, Шалгалтын хорооны гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч Э.Золзаяа, Шалгалтын хорооны гишүүн, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Мөнх-Эрдэнэ, Шалгалтын хорооны гишүүн, Замын хөдөлгөөний хяналтын прокурорын ахлах прокурор Д.Дамдинсүрэн, Шалгалтын хорооны гишүүн, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа, Шалгалтын хорооны гишүүн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, Герман, Европын эрх зүйн төвийн захирал Т.Золбоо,

солилцсон бөгөөд зарим нэг сайн туршлагыг нэвтрүүлэн ажиллаж байна. Ханнс Зайдалийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр Монголын Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны төлөөлөгчид ХБНГУ-ын Бавари мужийн Мюнхен хотод 2024 оны зургадугаар сарын 12-19-ны өдрүүдэд айлчилж, хуульчийн хоёрдугаар улсын шалгалтын талаар туршлага судалж, сургалтад хамрагдлаа.




Шалгалтын хорооны гишүүн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш Б.Баасандорж, Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс нар багтсан юм.



Тус айлчлалаар төлөөлөгчид нь ХБНГУ-ын Бавари мужийн Мюнхен хотын Хууль зүйн яамны төлөөлөгчид болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж, дугуй ширээний ярилцлага, хэлэлцүүлэг хийж, сургалтад хамрагдаж шалгалт зохион байгуулахтай холбоотой асуудал болон СПР сургалтын талаар, иргэний эрх зүйн чиглэлээр шүүх дээр дадлага хийх, Бавари мужийн хуульчийн улсын хоёрдугаар шалгалт хэрхэн явагдах, цахим шалгалтыг хэрхэн зохион байгуулдаг, мөн “Bay-learn” дижитал сургалтын платформ талаар, шалгалттай холбоотойгоор захиргааны хэргийн шүүхэд хандах асуудлыг хэрхэн зохицуулж буй талаар мэдээлэл авч, туршлага солилцсон юм. Мөн айлчлалын үеэр төлөөлөгчид Ханнс Зайделийн сангийн Мюнхен дэх төвийн үйл ажиллагаатай танилцаж, уулзалт зохион байгуулсан.

Шалгалтын хороо нь Монгол Улс дахь шалгалтын зохион байгуулалт болон бодлого, даалгаврын арга зүйг сайжруулахад ач холбогдол өгч ажиллаж байгаа бөгөөд тус айлчлалыг зохион байгуулсан нь үр дүнтэй, дараа дараагийн шалгалтыг зохион байгуулахад чухал хувь нэмэр оруулсан ажил боллоо хэмээн төлөөлөгчид дүгнэсэн.





**МОНГОЛЫН
ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО**

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ
ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ
2023 – 2025 ОНЫ ТАЙЛАН**